



НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Ёс зүйн дүрэм батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

2.Ёс зүйн дүрмийг нийт албан хаагчдад танилцуулж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ү.Ганболд/-т үүрэг болгосугай.

3.Энэ дүрэм батлагдсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны “Дүрэм батлах тухай” А/29 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ОЮУНЧИМЭГ

111020006515

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2021 оны 06 дугаар.....сарын
07-ны өдрийн ...139 дүрт... тушаалын
хавсралт



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмийн зорилго нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /цаашид “байгууллага” гэх/-ын төрийн албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг тогтоон хэвшүүлэхэд оршино.

1.2.Байгууллагын удирдлага нь энэхүү дүрмийг мөрдүүлэх, хэрэгжилт, биелэлтэд хяналт тавих, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх үүрэг хүлээнэ.

1.3.Албан хаагч энэхүү дүрмийг албаны өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгох бөгөөд ажлын бус цагаар төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндэд харшлах аливаа зохисгүй үйлдэл гаргахгүй байх, төрийн албаны нэр төр, ёс зүйг эрхэмлэн дээдэлж, хууль, дүрэм, журмыг сахин биелүүлэх үүрэгтэй.

Хоёр.Албан хаагчийн ёс зүйн зөрчил

2.1.Албан хаагчийн ёс зүйн зөрчил гэж холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” болон энэ дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл,эс үйлдэхүйг хэлнэ.

2.2.Төрийн хууль тогтоомжийг дээдлэх, өргөсөн тангарагтаа үнэнч байх, шударга ёсыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн тэгш байдлыг хангах нь албан үүргээ амжилттай гүйцэтгэх үндсэн нөхцөлийн нэг тул албан хаагч нэг бүрээс ёс зүйн хэм хэмжээг заавал сахин биелүүлэхийг шаардана.

Гурав.Ёс зүйн зарчим, хэм хэмжээ

3.1.Албан хаагч нь хууль дээдлэх зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

3.2.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа соёл, дэг журмыг чанд баримтлах, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;

3.3.Албан үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор танилцаж ашигласан нууцад хамаарах аливаа мэдээлэл, баримт бичигтэй танилцахдаа нууцын талаарх хууль тогтоомжийг баримтлах, бусдад задруулах, мэдээлэх, дамжуулах, үзүүлэх, хэвлэн нийтлэх, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй, тараахгүй байх;

3.4. Байгууллагын өмч, хөрөнгө, техник хэрэгсэл, албан хэрэгцээнд ашиглаж байгаа мэдээ, мэдээлэл, баримт бичиг, цахим мэдээлэл (файл)-ийн санг албаны бус зориулалтаар ашиглахгүй байх, албаны унааг зөвхөн албан хэрэгцээнд зориулалтын дагуу ашиглах;

3.5. Албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлэн ашигласан, өөртөө болон бусдад давуу байдал бий болгосон, ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн аливаа үйлдэлтэй эвлэрэхгүй байх, холбогдох байгууллага албан тушаалтанд мэдэгдэх;

3.6. Удирдах албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх, захирах, захирагдах ёсыг баримтлах, дээд шатны албан тушаалтныг хуульд нийцсэн бодит баримт нотолгоонд тулгуурласан, үнэн зөв мэдээллээр хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлого шийдвэртэй холбоотой асуудлаар зөвхөн албаны байр суурийг илэрхийлэх, худал мэдээлэл тараахгүй байх;

3.7. Албан тушаалтан үндсэн ажлаас гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил эрхлэхгүй байх, нийтийн албанд орох үед хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг гэрээгээр гүйцэтгэж, эрх эдэлж байгаа бол энэ тухай дээд шатны албан тушаалтанд танилцуулах;

3.8. Албан тушаалтан өөрийн үйл ажиллагааны шударга, төвийг сахисан байдалдаа ёс зүйн шалтгаанаар эргэлзээ төрвөл албан үүргээ гүйцэтгэхээс эсвэл давхар ажил, албан тушаал эрхлэхээс татгалзах;

3.9. Албан тушаалтан албан үүрэгтэй нь холбогдуулан аливаа этгээд бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд саналаас татгалзах, холбогдох этгээдийг тодорхойлох, хариуцлага хүлээлгэхээр зөрчил илэрсэн тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх;

3.10. Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлогын байдлыг хуулийн хугацаанд мэдүүлэх тэдгээрт орсон өөрчлөлтийн талаар эрх бүхий байгууллагад үнэн зөв мэдээлэх;

3.11. Өөрийн хамаарал бүхий этгээд, түүний ажиллаж байгаа байгууллага, холбоотой асуудлаар шийдвэр гаргах тохиолдолд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл тайлбарыг холбогдох байгууллага албан тушаалтанд гаргах;

3.12. Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах;

3.13. Хуульд заасан үндэслэлээр албан тушаал бууруулсан, чөлөөлсөн, халсан тухай шийдвэр гарсан тохиолдолд албан тушаал, ажлын байр, тамга, тэмдэг, холбогдох баримт материалыг хүлээлгэн өгөх;

3.14. Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах;

Дөрөв.Тэгш байдлыг хангах зарчмын хүрээнд

4.1.Улс төрийн албан хаагчаас бусад албан хаагч төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн аливаа нам, эвсэл, улс төрийн намын дэргэдэх төрийн бус байгууллага, шашны байгууллагын үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцохгүй байх, төрийн бодлого үйл ажиллагааг эсэргүүцсэн аливаа жагсаал цуглаанд оролцох, мэдээ, мэдээлэл тараахгүй байх;

4.2.Хүнийг нас, хүйсийн шинж, гэрлэлтийн байдал үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдлаар ялгаварлах, гадуурхах, үгүйсгэх, хязгаарлахгүй байх;

4.3.Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэд, хамтран ажиллагсадтайгаа адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, төрийн үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүй хөнгөн шуурхай хүргэх, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдлаас сэргийлэх;

4.4.Хамт олны дунд ажил хэрэгч бус байдал бий болгох, бэлгийн сэдэл үүсгэх, үг хэлээр, биеэр, өөр бусад хэлбэрээр илэрхийлэх, бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироохгүй, тэвчишгүй орчин үүсгэхгүй байх;

Тав.Төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх зарчмын хүрээнд

5.1.Төрийн албаны нэр хүндийг ямагт дээдэлж, түүнд харшлах аливаа үйлдлийг цээрлэх;

5.2.Албан томилолт болон хувийн ажлаар гадаад улсад зорчихдоо Монгол Улсын нэр хүндэд харшлах аливаа үйлдэл гаргахгүй байх, эрх бүхий албан тушаалтны гаргасан удирдамж чиглэлийг чанд баримтлах, төлбөрт, бооцоот тоглоом тоглох, энэ төрлийн үйлчилгээний газраар үйлчлүүлэхгүй байх;

5.3.Албан үүргээ гүйцэтгэж байхдаа буюу ажлын байрандаа согтууруулах ундаа, мансуурах бодис, утаат тамхи хэрэглэх, эдгээрийг ажлын байранд нэвтрүүлэх, этгээд байдлаар хувцаслах, (жинсэн өмд, задгай углааш, гэрэлтдэг хувцас, энгэр задгай цамц, хэт богино юбка, шорт зэрэг), бүдүүлэг зан авир гаргахгүй байх;

5.4.Төрийн байгууллагын бодлого, хууль ёсны үйл ажиллагааг эсэргүүцэх, үндэслэлгүй, худал мэдээ, мэдээлэл тараахгүй байх, өөрийн удирдлагад байгаа албан хаагчдад зөв үлгэр жишээ үзүүлэх;

5.5.Өөрийн удирдлагад байгаа ажилтныг айлган сүрдүүлэх, доромжлох, бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах, нэр хүндийг нь унагах, хууль бус үйлдэл хийхийг шаардахгүй байх;

Зургаа.Ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага

6.1.Энэхүү дүрмийг зөрчсөн албан хаагчид зөрчлийн шинж байдлыг харгалзан холбогдох хууль, дүрэмд заасны дагуу хариуцлага ногдуулна.